

Тус холбооны үйл ажиллагаа нь өмнөд хөршөөсөө сурах, тэдний туршлагыг амьдралын янз бүрийн салбарт нэвтрүүлэх, дэлхийн олон орны ижил төстэй зорилго бүхий холбоо, нийгэмлэг, хувь хүмүүстэй хамтран ажиллах, хоёр орны харилцаа, БНХАУ-ын социалист байгуулалтын өнөөгийн байдал, түүх соёл, утга зохиолоос монголын олон нийтэд танилцуулах, онол, практик, эрдэм шинжилгээний бага хурал, дугуй ширээний ярилцлага, лекц, мэдээлэл уулзалт хийх, хятад хэлний анхан шатны болон гүнзгийрүүлсэн сургалт явуулах зэрэг олон талт арга хэмжээ явуулахад чиглэнэ.

МХСХ-ны анхдугаар хурлаар холбооны дүрэм, хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, холбооны тэргүүлэгчдээр 9 хүнийг сонгож батлав. Тус холбооны ерөнхийлөгчөөр БНМАУ-ын Гадаад явдлын Яамны ажилтан, хятад судлаач Х. Аюурзаныг сонгов.

Монгол, хятадын ард түмний харилцан ойлголцол, итгэлцийг бэхжүүлэх үйл хэрэгт Монголын хятад судлалын холбоо байгуулагдсан явдал урагшлуулагч алхам болох нь дамжиггүй. Эв найрамдлыг дээдлэх ариун үйлсэд анхны алхам багадахгүй. БНМАУ, БНХАУ хөрш хоёр орны хувьд сайн хөршийн ёсоор зэрэгцэн орших нь энх тайван, дэвшил хөгжлийн эрх ашигт нийцэж байна.

МОНГОЛЫН ЯПОН СУДЛАЛЫН ТӨВ

О. Хонгорзул

Япон улс эртний түүх, соёл, уламжлал, зан заншлаа эрхэмлэн хадгалж, эдүгээ шинжлэх ухаан, техник, эдийн засгийн хөгжлөөр гайхагдаж байгаа нь дэлхийн улс түмний анхаарлыг арга буюу татаж байна.

Сүүлийн үед дорнодахины ард түмний соёл урлаг, зан заншил, түүхийг дэлхийн олон оронд ихэд сонирхон судлах болов. Нэн ялангуяа япон судлал улс орон бүрт өргөжин тэлсээр байна. Үүний нэг илрэл бол манай оронд 1989 оны 7-р сард Монголын япон судлалын төв байгуулагдсан явдал юм.

Тус төвийн зорилго нь монгол, японы ард түмэн харилцан бие биеэ ойлголцох, түүх соёлоо гүнзгийрүүлэн судлахад тус дөхөм үзүүлэх, түүнчлэн дэлхийн бусад орны ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, өөрийн орны судлаачдын хүчийг төвлөрүүлэн японы шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг нарийвчлан судлаж нийгэмд өгөөжтэй, хүртээмжтэй зүйлийг судлан үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хамтын ажиллагааны шинэ, шинэ хэлбэрийг бий болгож ажиллахад оршино.

Монголын япон судлалын төв нь өнгөрсөн хугацаанд «Сузуки хаи биоин» хэмээх шүдний эмнэлэг, Улаанбаатарын шүдний төв эмнэлгийн хооронд зуучилж шууд холбоо тогтоолоо. Ингэснээр туршлага солилцох шууд боломжтой болов. Төв байгуулагдсаныг тохиолдуулан тус төвөөс «Япон орон, япончууд» хэмээх номын эхийг бэлтгэж Мон-

голын эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгийн шугамаар өнгөрөгч оны 9-р сард хэвлэлд шилжүүлээ.

Үүний сацуу японы талтай ажил төрлийн холбоо тогтоож, материаллаг баазтай болох талаар голлон ажиллав. Тус төвийн үйл ажиллагаанд манай улсад суугаа Японы Элчин сайдын яам байнга тус дэмжлэг үзүүлж, тухайлбал, 900 гаруй долларын үнэтэй ном, сэтгүүл бэлэглэлээ.

Одоогоор 70 гаруй гишүүнтэй Монголын япон судлалын төв нь цаашид Японы томоохон хэвлэлийн пүүсийн тоонд ордог «Шинь Жинь буцу оорайся» пүүс, Японы Азийн соёлын судлалын хүрээлэн, Токиогийн хүүхэлдэйн киноны студи зэрэг байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож ажиллах юм.

Төвийн шугамаар хичээллэж буй япон хэлний дугуйланд одоо 20-иод хүн суралцаж байна. Дугуйлангийн сонсогчдоос түргэвчилсэн аргаар япон хэлний тодорхой мэдлэгтэй болж болохуйц сурах бичиг гаргахаар бэлтгэж байгаа болно.

Монгол, японы харилцаанд шинэ үе шат нээгдэж буй өнөө үед хоёр орны ард түмний итгэлцэл, харилцан ойлголцох, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд манай улсад анх удаа байгуулагдаж буй олон нийтийн сайн дурын энэ байгууллага зохих хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

Дорнодахины судлалын хүрээлэнд байрлаж буй Монголын япон судлалын төвд гишүүнээр элсэхийг хүсэгчдэд манай үүд үргэлж нээлттэй байх болно.